

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИННОВАЦИ, МЭРГЭЖЛИЙН ЦАГДААГИЙН ХЭРЭГЦЭЭ

Илтгэгч: Хууль сахиулахын их сургуулийн МАТ-ийн багш,
докторант, хууль зүйн магистр Лосолын ЦОГТБАЯР
Харилцах хаяг: Moncpfgensec@yahoo.com mobile num: 99117460

Хураангуй:

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн, тархалт, хохирол, гэмт хэрэг үйлдэгсэдийн талаарх криминологийн шинжийг статистикийн мэдээлэлд үндэслэн илэрхийлэхийн зэрэгцээ дэлхийн зарим улс оронтой харьцуулан гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны чиг хандлагад дүгнэлт хийж, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны инноваци, мэргэжлийн цагдаагийн хэрэгцээг тодорхойлсон болно.

Удиртгал

Мэдлэг нь үндэстний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгааны салшгүй хэсэг мөн.

Аливаа ард түмэн бол үндэстний жинхэнэ баялаг бөгөөд хүмүүсийн эрүүл саруул аж төрж, урт наслах, бүтээлчээр ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлж өгөх явдал нь хөгжлийн үндсэн зорилго байдаг.

Хүн төрөлхтөн эд баялаг, бодит зүйлсийг бий болгохын төлөө зорьж тэмүүлэн ирсэн боловч хөгжил дэвшил бүхэллэг байдлаараа хүний хөгжлийн төлөө гэдгийг анхаараагүй.

Хүний хөгжил гэдэг нь хүний эрх чөлөөт сонголтуудыг өргөжүүлэх үйл явцын нэгдэл мөн.

Хүний хөгжил нь бүсэд үзэл баримтлалыг бодвол илүү **холистик** асуудал байдаг.

Хүний нөөцийн хөгжлийн үзэл баримтлалаар зөвхөн хүний үнэт зүйлийг чухалчилж, хүмүүсийг хөгжлийн үйл явцын үр шимийг хүртэгсэд бус харин орц нь гэж үздэг.

Суурь хэрэгцээний онол нь хүмүүсийн сонголтыг бус харин тэдний наад захын хэрэгцээг авч үздэг. Харин нийгмийн **халамжийн онолын** талаас авч үзвэл хүмүүс өөрсдийнхөө ахуй амьдралыг төлөвшүүлэх үйл явцад идэвхтэй оролцогчид бус харин ач тусыг нь идэвхгүйгээр хүртэгсэд л байдаг.

Эдгээр бүх асуудлыг бүрэн хамарч байдгаараа “хүний хөгжил” нь хөгжил дэвшилд хандах илүү **холистик**¹ үзэл баримтлалд үндэслэдэг. Хүний хөгжил нь “**хүний эрх, хүний аюулгүй байдал, жендэрийн эрх тэгш байдал, байгаль орчны тогтвортой байдал болон мянганы хөгжлийн зорилтуудтэй нягт уялдаатай**”.

Хүн төрөлхтөн хүний хөгжилд нөлөөлдөг сөрөг үзэгдлийг “**гэмт үзэгдэл**”, харин нэгж үйлдлийг “**гэмт хэрэг, зөрчил**” гэж салбар хуульд тодорхойлж улмаар түүнтэй тэмцэх тогтолцоог сонгодог хэлбэрээр нь бий болгож, хөгжүүлсээр 200 орчим жил болж байна².

Нэг. Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага

¹Бүхэллэг гэсэн утгатай арга барил бөгөөд монголчуудад илүү тохиромжтой. Өрнийхөн нэг зүйл дээр төвлөрч сурч, ажиллаж, амьдардаг бол монголчууд цогц зүйлийг эрхэмлэдэг. Энэ нь нүүдлийн соёл иргэншилтэй холбоотой өөрсдөө бүгдийг хийж, бүтээж, бүхнийг сурч, бүхнийг мэддэг, бүхнийг чаддаг байх хандлагыг илэрхийлдэг.

Нийгэм гэдэг нь өргөн утгаараа хүмүүсийн зохион байгуулалттай, чиг зорилготой харилцаа, үйл ажиллагааны систем, тэдгээрийн үр дүнд бий болсон үнэт зүйлсийн нэгдэл, өөрийгөө байнга нөхөн сэргээж байдаг бие даасан бүхэллэг тогтолцоо.

²Анхны сонгодог хэлбэрийн Цагдаагийн байгууллага Англи Улсад 1829 онд “metropolitan police буюу их хотын Цагдаа гэх мэргэжлийн байгууллага үүссэн байна.

Хүн төрөлхтөн хүний хөгжилд нөлөөлдөг сөрөгүйл явц болох гэмт үзэгдлийг “бүтэц, түвшин, хөдөлгөөн” гэсэн үндсэн үзүүлэлтийнх нь хүрээнд математик загварчлал арга зүйг ашиглан шинжилж, прогноз гаргаж, бодлого тодорхойлох учиртай.

Гэмт үзэгдлийн бүтэц нь нийт гэмт үзэгдэлд эзлэх тодорхой төрлийн гэмт үзэгдлийн хувийн жин,

Гэмт үзэгдлийн түвшин нь нийт хүн амын дүнд эзлэх бүртгэгдсэн гэмт хэрэг ба гэмт хэрэг үйлдэгсдийн хувь,

Гэмт үзэгдлийн хөдөлгөөн нь тодорхой хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт бууралтыг илэрхийлнэ.

Монгол Улс дахь гэмт үзэгдлийн бүтэц, түвшин хөдөлгөөнийг жил бүр албан ёсоор гаргаж, дүн шинжилгээ хийдэг боловч хэрэглээ байхгүйн улмаас зөвхөн судалгааны түвшинд ашиглагдаад өнгөрдөг. Нөгөө талаар гэмт хэргийн мэдээ, шинжилгээний үр дүн, мэдээллийг нууц гэж эндүүрэх тохиолдол ч байсаар байгаа нь харамсалтай мэт.

Гэмт үзэгдэл судлалын шинжлэх ухааны үндсэн дээр нутаг дэвсгэрийн нэгж бүрээр гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлах ажлын үр дүнд хүн амынх нь ихэнх суурьшдаг Улаанбаатар хот болон төвийн бүсийн Дархан, Эрдэнэт зэрэг хүн ам төвлөрсөн хотуудад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо буурдаггүй жишиг тогтож байна.

Онолын үүднээс гэмт үзэгдлийн бүтэц, түвшин, хөдөлгөөнийг тогтооход дараахь үндсэн ойлголтуудыг заавал тусгах шаардлагатай. Үүнд:

1. Бүртгэгдсэн гэмт хэрэг
2. Бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл
3. гэмт хэргийн илрүүлэлтийн хувь зэрэг болно.

Гэмт үзэгдлийн бүтэц, түвшин, хөдөлгөөнийг тогтооход гэмт хэргийн ба хэв журмын нөхцөл байдлын үнэлгээг тодорхойлох чухал ач холбогдолтой.

Монгол Улсын хэмжээнд 2003-2013 онд³ нийт **197959**(*жилд дундажаар 19796*) гэмт хэрэг бүртгэгдэж улс болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нийт **380.6 тэрбум**(*жилд дундажаар 38.1 тэрбум*) төгрөгөөр хохироож, нийт **15746**(*жилд дундажаар 1575*) хүн нас барж, нийт **74517** (*жилд дундажаар 7452*) хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтсэн байна.

Албан ёсны статистикийн мэдээлэлд⁴ үндэслэн тооцоолоход жилд дундажаар 16 ба түүнээс дээш насны **10 000** хүнд **109, 100 000** хүнд **1093** гэмт хэрэг, 18 ба түүнээс дээш насны **10 000** хүнд **117, 100 000** хүнд **1167** гэмт хэрэг тус тус ногдож байгаа нь Монгол Улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг бусад улс оронтой харьцуулах бодит үзүүлэлт.

Энэ тоон мэдээлэлд үндэслэн тодорхойлоход хүн ам багатай манай улсын хувьд гэмт хэрэг үйлдэгдэх түвшин өндөр, хохирол их байгаа нь харагдаж байна.

График-1

³2003-2012 он

⁴ Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны гаргасан хүн амын мэдээлэл





График-2




Гэмт хэргийн ангилал:

Нийт 2003-2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 37.2 хувь нь хөнгөн, 48.3 хувь нь хүндэвтэр, 12.4 хувь нь хүнд, 2.2 хувь нь онц хүнд ангиллын гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Үүнээс үзэхэд ил цагаан үйлдэлтэй, энгийн нөхцөлтэй өөрөөр хэлбэл Эрүүгийн хууль⁵-д хөнгөн, хүндэвтэр гэж ангилсан гэмт хэрэг нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 85,5 хувийг эзэлж байна.

Харин үндэсний аюулгүй байдлын, хүний аюулгүй байдлын, эдийн засаг, мэдээлэл, байгаль орчны аюулгүй байдлын эсрэг нууц далд аргаар үйлдэгдсэн гэх гэмт хэргийн бүртгэгдсэн гэх байдал 2.2 хувь эзэлж байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт.

⁵Эрүүгийн хууль, 17 дугаар зүйл, 2002 он



Хоёр. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ба гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдал

Хүлээн авч, шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл:

Улсын хэмжээнд хууль сахиулах байгууллага (**Цагдаагийн байгууллага**) судалгаанд хамрагдсан 2011-2016 он буюу 6 жилийн хугацаанд нийт **1851977** гомдол, мэдээлэл хүлээн авч үүнээс гэмт хэргийн шинжтэй нийт **486699** гомдол, мэдээллийг шалган **230361** тохиолдолд буюу 47,3 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр **310592** тохиолдолд буюу 63,8 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хугацааны хувьд 0-5 хоногт **226674** буюу 42,4 хувь, 6-19 хоногт **260054** буюу 57,6 хувийг шалгасан.

Бүртгэж, мөрдөн шалгасан гэмт хэрэг:

Улсын хэмжээнд 2011-2016 онд нийт **148890** (өсөлт 33,9 хувь) гэмт хэрэг бүртгэсэнээс хөнгөн гэмт хэрэг **69325** (илрүүлэлт 61,2 хувь), хүндэвтэр гэмт хэрэг **66289** (илрүүлэлт 57,2 хувь), хүнд **10305** (илрүүлэлт 70,1 хувь), онц хүнд **2971** (илрүүлэлт 86,6 хувь), нийт илрээгүй **26412** гэмт хэргээс **19422** хулгайлах гэмт хэрэг, **1786** танхайрах гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байна.

Эндээс үзэхэд бүртгэсэн нийт гэмт хэргийн 92,1 хувийг ил цагаан үйлдэлтэй, энгийн нөхцөлтэй, хохирол багатай хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд ийм төрлийн хэргийг мөрдөн шалгаж бүхий л хүн хүч, цаг хугацаа, хөрөнгө мөнгийг ямар нэгэн үр дүнгүй зарцуулдаг жишиг тогтсон байна.

Гурав. Гэмт хэрэгтэй тэмцэх инноваци ба гэмт хэргийн статистик судалгаанд кластр⁶ шинжилгээг ашиглаж тодорхойлох нь

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийг 1990-2016 оны дүнгээр нэгтгэн бүлэглэн өсөлтийн хурдыг тодорхойлоход 1990 онд 9060 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2000 онд 2463 гэмт хэрэг бүртгэсэн нь өсөлтийн хурд 10 хувиар байсан бол 2016 онд 27000

⁶Зөвхөн нэг шинжээр нь бүлэглэх бус олон хүчин зүйлийг харгалзан бүлэглэн шинжлэх, дүгнэх цогц үйл ажиллагаа. Цагдаагийн байгууллагын мэргэжлийн чадварыг бэхжүүлэхдээ гэмт хэрэгтэй тэмцэх газарзүйн байршил, онцлогоор нь нягт уялдуулж, улмаар иргэдийн аюулгүй байдлыг хангах, баталгаажуулах хүрээнд **хууль зүйн болон инновацид** (мэдлэг) түшиглэх гэсэн хоёр хандлагаар кластерийг хөгжүүлж байна.

Кластерийн дүн шинжилгээний сургамж: **нэгдүгээрт**, улс орон/бүс нутаг бүхэн өөрийн өвөрмөц кластерийн хольцтой; **хоёрдугаарт**, кластер бол өөрчлөлт болон сонголтын орчноороо ялгаатай; **гуравдугаарт**, улс орны онцлог, түүх, мэдлэгийг эзэмшиж буй хэлбэр, кластерийн хөгжлийн түвшин, сүлжээг үүсгэх практик туршлага гэх зэргээс үүдэн инновацийн кластер гэсэн ойлголт төөрөгдлийг бий болгодог; **дөрөвдүгээрт**, технологийн ба технологийн бус инновацийг нээлттэй авч үзэх шаардлагатай.

гэмт хэрэг бүртгэгдсэн нь 0,9 хувийн хурдтай өсөлт байгаа бөгөөд 1990-2016 оны нийт хугацаанд нь авч үзвэл өсөлтийн хурд 4,2 байна. Бүсийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг Улаанбаатарт 65 хувь, төвийн бүс 14 хувь, хангайн бүс 11 хувь, баруун болон зүүн бүс тус, тус 5 хувь ногдож байна.

Монгол Улсын гэмт хэргийн байдлыг дэлхийн зарим улстай харьцуулах нь:

Ази номхон далайн бүсийн хөгжиж байгаа улс орнуудын хэмжээнд 2005-2012 онуудад бүртгэгдсэн гэмт хэргийг 0-4 хувийн түвшингээр авч үзэхэд 0,7-0,5 хувийн бууралттай байсан бол Ази номхон далайн бүсийн хөгжингүй улс орнуудын хэмжээнд 2005-2012 онуудад бүртгэгдсэн гэмт хэрэг 3,7-2,5 хувийнх түвшинтэй харин ял эдэлж байгаа хүн 100 мянган хүн тутамд Казахстанд 340, ОХУ-д 540, **Монголд 290**, Солонгос 90, Японд 58, Гонконг 129, Хятад 120 хүн байна. Үүнээс, бүртгэгдсэн дээрмийн гэмт хэрэг 100 мянган хүн тутамд ОХУ-д 90, Солонгос 9, Монголд 19, Японд 4, Хятад 11 байна.

Эндээс үзэхэд дэлхийн ихэнх улсад гэмт хэрэг буурах хандлагатай байхад манай улсад эсрэгээрээ тогтмол өссөн, цаашид өсөх хандлагатай гэж дүгнэхийн зэрэгцээ ял эдэлж байгаа хүний тоо Ази болон бусад оронуудтай харьцуулахад маш өндөр үзүүлэлттэй байгаа нь хууль эрх зүйн орчин болон гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх онол, арга зүй, сэтгэлгээг эрс өөрчлөх, инноваци нэвтрүүлэх шаардлагатай байна.

Кластер шинжилгээнд ашигласан статистик үзүүлэлт

X ₁ Хүн амын тоо	X ₇ Согтуугаар үйлдсэн
X ₂ Хүн алах	X ₈ Залилах
X ₃ Хулгайлах	X ₉ Хүчиндэх
X ₄ Дээрэмдэх	X ₁₀ Эмэгтэй хүн оролцсон
X ₅ Мал хулгайлах	X ₁₁ Боловсролгүй
X ₆ Танхайрах	X ₁₂ Илрүүлэлтийн хувь

Дисперсийн шинжилгээний үр дүн (4 кластераар)⁷

Үзүүлэлт	Бүлэг хоорондын дисперс	Бүлгүүдийн дисперс	F статистик	Ач холбогдол
X ₁ Хүн амын тоо	18.0984	7.90158	17.56036	0.00004
X ₂ Хүн алах	16.17192	9.82808	12.61535	0.000044
X ₃ Хулгайлах	20.54566	5.45434	28.87917	0.00000
X ₄ Дээрэмдэх	23.59315	2.40685	75.15268	0.00000
X ₅ Мал хулгайлах	12.36498	13.63502	6.95255	0.001697
X ₆ Танхайрах	21.31103	4.68897	34.84441	0.00000
X ₇ Согтуугаар үйлд	20.31582	5.68418	27.40143	0.00000
X ₈ Залилах	24.07971	1.92027	96.13699	0.00000
X ₉ Хүчиндэх	16.50973	9.49027	13.33730	0.000030
X ₁₀ Эмэгтэй хүн оролцсон	23.29748	2.70252	66.09159	0.00000
X ₁₁ Боловсролгүй	14.67286	11.32714	9.9118	0.00216
X ₁₂ Илрүүлэлтийн хувь	17.04868	8.95132	14.60193	0.000015

⁷П.Мөнхтуяа доктор. “Гэмт хэргийн статистик”, ЭШХ-ийн илтгэл, 2017.04.27.

Кластер хоорондын зайг дараах хүснэгтээр илэрхийлбэл⁸

Кластер	1	2	3	4
1	0.000000	4.160233	5.957637	3.415323
2	2.039665	0.000000	0.331056	0.49183
3	1.989381	0.575374	0.000000	1.030050
4	1.848059	0.705112	1.014914	0.000000

Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгсэн түвшний олон хэмжээст шинжилгээний дүн⁹

Кластер 1 Өндөр	Кластер 2 Дунд	Кластер 3 Дундаас доогуур	Кластер 4 Доогуур
БГД БЗД СБД СХД ЧД	Баян Өлгий Дорнод Ховд Өвөрхангай Орхон Дорноговь Хэнтий Сэлэнгэ Баянхонгор Төв	Завхан Увс Говьсүмбэр Дархан ХУД Архангай Өмнөговь	Сүхбаатар Дундговь Булган Говь-Алтай

Хууль сахиулах салбарт тэр тусмаа Цагдаагийн байгууллагад сэтгэл болон сэтгэц зүйн шинжлэх ухааны мэдлэгт суурилсан хүний нөөцийн удирдлагын түвшинд эрс өөрчлөлт шаардлагатай байгааг эдгээр судалгааны үр дүн илэрхийлж байна.

Учир нь нийтийн хэв журам, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиг үүрэгтэй, үүрэгжсэн байгууллагыг мэргэжлийн (байгаль орчин, тээврийн, уул уурхай, газар тариалан, хөдөө аж ахуйн, үйлдвэрийн гэх мэт) болгох, алба хаагч нарыг мэргэшүүлэх ажил шаардлагатай байна.

Орчин үед хууль сахиулах салбарын хүрээ өргөжихийн зэрэгцээ энэ салбарын алба хаагч нарт хамааралтай сэтгэл болон сэтгэц зүйн боловсрол, мэдлэг, чадвар олгох сургалтын тогтолцооны хандлагын асуудал хэрэгтэй болжээ.

Эрх зүйт нийгэмшил ба сэтгэц зүй

Монгол Улсын оршин тогтнох, хөгжин дэвших эх сурвалж бол Монгол хүний тасралтгүй хөгжиж байх, оюун ухааны чадварт суурилсан боловсрол мөн.

Аливаа сургалт нь тухайн хүний дотоод, гадаад чадварт суурилдаг учиртай тул хууль сахиулах төдийгүй сургалтын бусад үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахын тулд нийгэм, сэтгэл зүй, соёл, зан заншлын уламжлал, өнөө, ирээдүйн төлөвийн хамаарлыг харгалзах шаардлагатай.

⁸П.Мөнхтуяа доктор. “Гэмт хэргийн статистик”, ЭШХ-ийн илтгэл, 2017.04.27.

⁹“Гэмт хэргийн статистик”, ЭШХ-ийн илтгэлийн эмхтэл, 2017.04.27.

Сургалт нь 2000 он хүртэл боловсрол олгохын төлөө байсан бол одоо зорилготой, зөв ёс зүй, зан төлөвшил, сэтгэл зүйн чадвар бий болгох боловсролын салбарын хөгжил рүү чиглэх боллоо.

Хүний нөөцийн шинжлэх ухаан нь HRM буюу хүний нөөцийн менежмент, **HRD** буюу хүний нөөцийн хөгжил гэсэн 2 үндсэн хэсгээс бүрддэг. Энэ хоёр ойлголтыг хүн-баялгийг зөв удирдан зохион байгуулж, тасралтгүй хөгжүүлэх цөм механизм гэж тодорхойлж болно.

Монгол Улсад **нэгд**, хүн баялагаа системтэй тасралтгүй бэлтгэдэг цогц тогтолцоо байхгүй **хоёрт**, хүний нөөцийн хөгжил, сургалт нь амин чухал зүйл гэдгийг бүрэн ойлгоогүй, хүлээж авахгүй байгаа нь аль ч байгууллагын алсын хараа, эрхэм зорилго тодорхойгүй ойлгомжгүй, хийсэн ажлуудын гүйцэтгэл нь үр дүнгүй болгоход хүргэж байна.

Багш төвт, тусдаа салангид олон **“зөв хариулт”** сургаж байгаа боловсролын системийг өөрчилж, ямар зорилготой, эрэл хийж байгаагаа тодорхой танилцуулаад яаж хийхээ **“асуу”** гэсэн шавь төвт сургалтын зарчим руу чиглэх шаардлагтай.

Боловсролын системийн өөрчлөлтийн гол арга хэмжээнүүд бол суралцах хүсэлтэй хүмүүст хүртээмжтэйгээр боловсрол олгож, нийгэм, ажил олгогчдын зүгээс тавьж буй нарийвчилсан шаардлагад нийцэх стандартыг тогтоон, мэргэшсэн багш бэлтгэн, боловсролын үнэлгээг шинэчлэх явдал.

Иймд хурдацтай өөрчлөгдөн буй нийгмийн хэрэгцээ шаардлагад өнөөгийн боловсролын систем бүрэн дүүрэн нийцэж байгаа эсэхийг эргэж харж, шинэ үеийн мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах цаг болсон.

Дүгнэлт

1. Эрх зүйн шинэтгэлийн үр дүнд хууль сахиулах байгууллагын болон үйл ажиллагааны эрх зүйн орчин батаалгаажсан боловч алба хаагчдын сэтгэц зүйн болон сэтгэлгээ, албаны мэдлэг, хөтөлбөрт сургалтын тогтолцоонд хоцрогдох хандлага бүхий нөхцөл бүрэлдсэн нь бодит зүйл болсон байна.

2. Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг тоо 1990-2016 оны хугацаанд байнга өссөн, өсөлтийн дундаж хурд 4,2 хувь, 1990-2000 оны бүртгэгдсэн гэмт хэргийн өндөр түвшин одоо болтол хадгалагдаж байна.

3. Судалгааны үр дүнд үндэслэн тухайн кластерт тодорхойлогдсон гэмт хэргийн төрлөөс хамааран урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаа явуулах боломжтой.

4. Гэмт хэргийн хамгийн өндөр түвшинтэй ангилалд Улаанбаатар хотын дүүргүүд орж байгаа нь хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөн, зорчигчийн эргэлт, сэтгэл зүйн дарамт, үзэл бодолын төөрөгдөл, сэтгэлгээний ядуурал зэрэг нийгэм, эдийн засаг, хүмүүжил, боловсрол зэрэг хүчин зүйлүүдтэй салшгүй холбоотой бөгөөд кластер тус бүрд тохирсон хууль эрх зүй, төсөв, удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг харуулж байна.

5. Судалгааны дүн зөвхөн тоон үр дүнг төдийгүй Монгол Улсад мөрдөж буй хууль эрх зүйн орчны талаар баримталж буй бодлого, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын бүтэц, хүний нөөцийн удирдлагыг өөрчлөх, сайжруулах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Санал

Нэг. Дараах төрөлийн хөтөлбөрт сургалтыг уламжлал, шинэчлэл, олон улсын хандлагад нийцүүлэн хэрэгжүүлэх. Үүнд:

1. Сэтгэл зүйн сургалт,
2. Ёс зүй, ёс суртахуун, гоо зүйн сургалт,
3. Хууль зүйн буюу хүний эрхийн сургалт,
4. Оюуны сургалт буюу мэргэжлийн мэдлэг олгох сургалт,
5. Бусад шинжлэх ухааны сургалт
6. Биеийн хүчний сургалт,

Амьдралын шинжлэх ухааны сургалтыг оновчтой зохион байгуулах нь салбарын хөгжилд үнэт зүйл болох боломжтой болно.

Хоёр. Байгууллагын болон алба хаагчийн талаар

1. Цагдаагийн байгууллагыг мэргэжлийн чиг хандлагад зохион байгуулах
2. Алба хаагч нарийг мэргэшүүлэх
3. Хүний нөөцийн бодлогыг баримт бичиг, эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай.